

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-26

1.Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох 3-26

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
10 дугаар сарын 08-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 22 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтаншагай, С.Амарсайхан, О.Амгаланбаатар, П.Батчимэг, С.Ганбаатар, С.Лүндэг, С.Одонтуяа, У.Отгонбаяр, Ц.Туваан, Ж.Чинбүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Бат-Эрдэнэ, С.Замира;
Тасалсан: Ц.Мөнхбат.

Нэг.Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Алтантуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Байгаль орчны улсын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Химийн бодис, аюултай хог хаягдлын хяналт хариуцсан шинжээч Э.Уугантуяа, Хөрсний хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Ү.Бат-Эрдэнэ, Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх, мөн газрын шинжээч А.Оюун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Мөнхнасан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын дарга М.Ням-Очир, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, мөн газрын мэргэжилтэн Б.Уянга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын газрын дарга Г.Билгүүн, Нийслэлийн Засаг даргын зөвлөх Ө.Ганболд, “Экостандарт петролеум” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Б.Еркебулан, мөн компанийн Гүйцэтгэх захирал Б.Наранцацрал, Хог хаягдлын асуудлаарх олон улсын зөвлөх Б.Дэлгэрбаяр, Хог хаягдлын судлаач, зөвлөх С.Аригуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл,

Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороо хариуцсан референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Б.Уянга, Б.Мөнхсоёл, Н.Наранбаатар, Б.Бейсен нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх, Байгаль орчны улсын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Алтантуяа, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ж.Батжаргал, Б.Уянга, Б.Бейсен нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Бейсен тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 20 минут үргэлжилж, 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр,

Лхагва гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”

танхим

12 цаг 22 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 53.3 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 8-ны өдөр хуралдааныг нээснийг мэдэгдье. Хуралдааны ирцийг танилцуулъя.

Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн байна. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна. Ренчинбямбын Сэдэددорж гишүүн ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн байна. Загджавын Мэндсайхан гишүүн ирсэн байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн ирсэн байна. Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанд хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох, хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу?

Саналтай гишүүн байхгүй байна.

Хэлэлцэх асуудалд оръё. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя.

Б.Батбаатар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Сангийн яамнаас Ж.Алтантуяа Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч ирсэн байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Ч.Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч, Б.Мөнхтогтох Байгаль орчны улсын хяналтын газрын дарга, Уугантуяа Химийн бодис, аюултай хог хаягдлын хяналт хариуцсан шинжээч, Ү.Бат-Эрдэнэ Хөрсний хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Г.Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга, А.Оюун Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын шинжээч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Мөнхнасан, Ц.Мөнхнасан Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч. Ирээгүй байна уу? Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас Б.Ням-Очир Нийтийн аж ахуйн бодлого,

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

зохицуулалтын газрын дарга. Байна уу Ням-Очир? Эрүүл мэндийн яамнаас Цэцэгсайхан, Б.Цэцэгсайхан Нийгмийн эрүүл мэндийн бодлого хэрэгжилтийн газрын дарга ирсэн байна Б.Уянгаа Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Г.Билгүүн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын газрын дарга, Үндэсний аюулгүй байдлын Тохижилт, хог хаягдлын газрын дарга ирсэн байна. Ө.Ганболд Нийслэлийн Засаг даргын зөвлөх, “Эко стандарт петролиум” ХК-ийн Б.Еркебулан хувьцаа эзэмшигч, Б.Наранцацрал Гүйцэтгэх захирал, судлаачид Б.Дэлгэрбаяр, Хог хаягдлын асуудлаарх олон улсын зөвлөх ирсэн байна. С.Аригуун Хог хаягдлын судлаач зөвлөх.

Мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батбаатар танилцуулна. 3 номерын микрофон.

Б.Батбаатар: Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Сүүлийн жилүүдэд манай улсын хүн амын тоо, үйлдвэржилт өсөн нэмэгдэхийн хэрээр хог хаягдлын хэмжээ нэмэгдэж байна. Үүний дотор аюултай хог хаягдлын хэмжээ 2023 онд 433.9 мянган тонн болж 2022 онтой харьцуулахад 133.5 мянган тонн буюу 23.5 хувиар буурсан мэдээтэй байна. Гэвч энэ бууралтад зөвхөн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас үүссэн хог хаягдал 138.1 тонн буюу 46.8 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Харин цахилгаан станц, дулааны үйлдвэрлэлээс үүссэн аюултай хог хаягдлын хэмжээ 2023 онд өмнөх оноос 1.8 мянган тонн буюу 1 хувь, уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдал 2.5 мянган тонн буюу 2.9 хувь, арьс шир, үслэг, ноос, ноолуур, ээрмэлийн үйлдвэрлэлийн аюултай хог хаягдал 0.1 мянган тонноор тус тус өсжээ.

Аюултай хог хаягдлын бүтцээс харахад 2020 онд нийт аюултай хог хаягдлын 76.7 хувь нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас, 21.4 хувь нь цахилгаан станц, дулааны үйлдвэрлэлээс үүсэж байсан бол 2023 онд 36.1 хувь нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас, 43.3 хувь нь цахилгаан станц, дулааны үйлдвэрлэлээс, 20.1 хувь нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн байна.

Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд Улсын Их Хурлын хэлэлцэн баталсан бөгөөд аюултай хог хаягдлыг савлах, түр хадгалах, тээвэрлэх, устгах, хадгалах, цуглуулах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх болон байгууламжийн байршилд тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэн зөвшөөрөл олгох, хяналт, шинжилгээ хийх, тайлагнах зэрэг аюултай хог хаягдлын менежменттэй холбоотой зохицуулалтыг шинээр зохицуулах болсон.

Мөн аюултай хог хаягдлын цахим мэдээллийн сан үүсгэж, үүсгэгчийн бүртгэлд одоогийн байдлаар 2088 аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдэж аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр буюу эрүүл мэндийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах, хаягдал аккумулятор, дахин боловсруулах, хаягдал техникийн тос дахин боловсруулах зөвшөөрлийг улсын хэмжээнд 26 аж ахуйн нэгж байгууллагад олгосон байна.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Аюултай хог хаягдлыг устгах чиглэлээр 2025 оны 6 дугаар сард Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Зэвсэгт хүчний дугаар ангийн ...-т хадгалагдаж байсан химийн хортой болон аюултай бодист зэвсэгт хүчний нэгдсэн лабораторийн үйл ажиллагаанд ашиглагдаж байсан хугацаа нь дууссан 33 төрлийн 89.29 литр химийн шингэн, 196 зүйлийн 406.86кг химийн хатуу хаягдал, хатуу бодисыг аюултай хог хаягдлын тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагад шилжүүлэн устгууллаа.

Салбарын хяналтаас 2023-аас 25 онуудын хооронд давхардсан тоогоор энгийн болон аюултай хог хаягдал үүсгэгч, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч 2069 иргэн, 1623 аж ахуйн нэгж, нийт 3692 объектыг хяналт шалгалтад хамруулж давхардсан тоогоор нийт 2211 зөрчил, дутагдал илрүүлж, 1637 буюу 74 хувийг нь арилгуулж, 326 этгээдэд 138 сая 400 төгрөгийн торгох шийтгэл, 1 тэрбум 60 сая төгрөгийн нөхөн төлбөр оногдуулаад байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 377 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газрын зориулалтаар 20 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, 2022 онд байгаль орчинд нөлөөлөх байдлын урьдчилсан судалгаа, дүгнэлтийг боловсруулж, 2025 онд аюултай хог хаягдлын байгууламжийн орлого, зарлагын эдийн засгийн тооцооллыг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу Эдийн засгийн хөгжлийн сайдад аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламжийн төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах хүсэлтийг хүргүүлээд байна.

Уг байршил нь хуучин цэргийн ангийн зориулалтаар ашиглаж байгаа, эвдэрч орхигдсон хүн амын суурьшлын бүс Улаанбаатар хотын идэвхтэй хагарал, геологийн хагарал, усны сан бүхий газрын хамгаалалттай бүс, усны урсац бүрэлдэх эхээс хуульд заасан зайд оршиж байгаа тул аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламжийг барих бүрэн боломжтой гэж үзэж байна.

Улсын хэмжээнд аюултай хог хаягдлыг түр хадгалах тээвэр, логистикийн сүлжээ бий болгох зорилгоор аюултай хог хаягдлын жишиг зургийг мэргэжлийн байгууллагаар батлуулж, Ховд аймаг, Ховд, Хөвсгөл аймгууд стандартын шаардлага хангасан төвлөрсөн хогийн цэгийг байгуулж байна. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүжилтээр 2020-оос 24 онуудад 15 аймаг, нийслэлд барьж байгуулахаар төлөвлөн ажилласан байна.

Одоогийн байдлаар Архангай, Өвөрхангай, Булган, Дундговь, Дархан-Уул зэрэг 5 аймагт аюултай хог хаягдлыг түр хадгалах хахуулийг барьж хүлээлгэж өгсөн. Харин нийслэлийн Баянзүрх дүүргийн Цагаан давааны хогийн цэг, Завхан, Хөвсгөл, Дорнод, Дорноговь, С.Сэлэнгэ, Төв, Баянхонгор, Орхон, Хэнтий Говьсүмбэр зэрэг 10 аймаг дүүрэгт хөрөнгө санхүүгийн байдлаас шалтгаалан барилгын ажил зогсонги байдалд орж гүйцэтгэл 70-80 хувьтай байна.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо татан буугдаж, санхүүжилтийн хүндрэл үүссэн хэдий ч 2026 оны Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцад 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийн саналыг тусгасан байгаа. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2019 онд аюултай хог хаягдлын жишиг зураг, 2024 онд хог хаягдлын төвлөрсөн цэгийн жишиг болон

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ангилан ялгах төвийн жишиг зургуудыг эрх бүхий байгууллагуудаар батлуулан аймаг, нийслэлд хүргүүлэн, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын тогтоолын хүрээнд 2024 оноос эхлэн хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн салбар, ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээл олгох салбар чиглэлд хамрагдаж эхэлсэн бөгөөд 5 аж ахуйн нэгжид 594.5 сая төгрөгийн зээл олгосон байна.

Цаашид олон улсад баримталж байгаа үүсгэгч нь хариуцах, бохирдуулагч нь төлөх зарчмуудыг хангах зорилгоор үйлдвэрлэсэн болон импортолсон зарим бараа, бүтээгдэхүүний хэрэглээнээс үүсэх хаягдал, сав, баглаа боодлыг эргүүлэн татаж, цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах асуудлыг үйлдвэрлэгч болон импортлогч нь хариуцах, үүсгэсэн хэмжээнээсээ хамаарч, төлбөр хураамж тооцох эрх зүйн зохицуулалтад зохицуулалтуудыг бий болгох чиглэлээр Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.

Ингэснээр хог хаягдлыг ангилж, ялгах үйл ажиллагаа сайжирч, хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр, үйлдвэрлэл эрхлэх сонирхол нэмэгдэн энэ чиглэлээр ЖДҮ-үүд бий болгох, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Баярлалаа.

Б.Бейсен: Батбаатар сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Уянгаа гишүүнээр тасалъя. Мөнхсоёл гишүүнийг нэмж оруулъя. Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Байнгын хорооны гишүүд өглөөний мэнд хүргэе. Хог хаягдлын асуудал, бас аюултай хог хаягдлын асуудал бас тодорхой хэмжээнд төрийн бодлогод тусаад ингээд явж байгаа. Тэгээд бас нэлээдгүй ажил ч бас төлөвлөөд байгаа юм байна. Би бол энгийн хог хаягдлын талаар бас энэ Байгаль орчны яамнаас хэд хэдэн зүйл тодруулах гэсэн юм. Хогтой бол нэлээн ноцолдсон хүн би. Тэгэхээр энэ хогны асуудлыг ер нь бид бас нэг талдаа гаргахгүй бол энэ хүний амьдралын чанар, хүрээлэн буй орчин, олон юманд маш их сөрөг нөлөөтэй. Одоо бид нар яаж байна гэхээр ландшифт нэртэй нүх ухаад л, булаад л байгаа. Нөгөө талдаа Байгаль орчны хууль дээр шатааж болохгүй эд нар гээд янз янзын бас хатуу зохицуулалтууд нь орчихсон. Тэгэхээр манай энэ төв суурин газрын энэ 330 сум, энэ 21 аймгийн төвийн хогийн бүтцийг харахаар мэдэхгүй тэгж айхтар шатаагаад эрчим хүч үйлдвэрлээд эд нар гэдэг тийм зүйл бол огт байхгүй.

Тэгэхээр бид энэ хогныхоо бүтэц юманд таарсан ер нь хогны менежментийг яаж хийх юм? Би нэг тодорхой зүйлийг л асуух гээд байгаа юм. Жишээ нь Орост билүү, Оросынх билүү хаанахынх билээ шатаадаг зуух утаа гаргахгүй гээд ингээд байгаа. Энэ ингээд төслүүд уул нь хэрэгжсэн гэж ингэж дуулсан. Тэгээд үүний үр дүн яг ямар байгаа юм бэ? Тэгэхээр Монгол Улсад өнөөдрийн байдлаар очоод үзчихье, жишээ авчихъя. Тийм хогоо ингээд зөв менежментэд оруулчихсан нэг ч газар байхгүй шүү дээ. Тэгээд л яг эцсийн дүндээ цуглуулдаг, аваачаад газар овоолдог тэгээд яг яах вэ гээд ингээд дараагийн шатад бол бүгд очоод л хана

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

мөргөж байгаа юм. Улаанбаатар хотод овоо харин дэвшилттэй юм явж байгаа юм байна лээ. Тэгэхээр би Байгаль орчны яамнаас энэ асуудал дээр бас яг ямар бодлого байгаа юм бэ? Энэ бол энэ яг төв суурин газар болгоны зовлон болчихсон, маш их хэмжээний мөнгө зарцуулдаг, үр дүн гардаггүй. Тэгээд төрийн албан хаагч нар, хүүхдүүд, хавар, намартаа цэвэрлэдэг эд нар гээд ийм маш их сөрөг үр дагавартай нэг зүйл байгаа.

Хоёр нэг дахь асуудал нь бол бас л байгаль орчинтой холбоотой, бас л орон нутагтаа аягүй тулгамддаг иргэн, төр хоёр хоорондоо мууддаг асуудал байна шүү дээ. Энэ юу вэ гэхээр нөгөө төв суурин газрын энэ малын асуудал байгаа юм. Нэг нь хавар, намартаа тарьдаг, нэг хэсэг нь болохоор үхэр мал оруулаад идүүлчихдэг. Иргэдийн хурлаараа болохгүй гээд шийдвэр гаргадаг. Тэр дээрээ зөрчсөн хүнийг ингээд арга хэмжээ авчихна даа гэхээр Хууль зүйн яам нь өнөөхийг нь бүртгэж өгдөггүй та нарт тийм эрх мэдэл байхгүй гээд. Ингээд хөөцөлдөөд ингээд явж байгаа. Тэгээд өнөөдөр ч гэсэн Улаанбаатар хотод тийм асуудал үүсээд л. Тэгэхээр энэ дээр Байгаль орчны яам бас тодорхой хууль, эрх зүйн өөрчлөлт хийгээд энэ тарьсан, ургуулсан юмаа хэдэн үхэр, мал, гахай идүүлчихгүйгээр байх юм хийж өгөөч ээ. Иргэдийн хурлынхан бол чадлаараа эрх хэмжээнийхээ хүрээнд үзээд байдаг юм. Энэ 330 сум энэ 21 аймагт яг энийгээ төгс шийдчихсэн нэг ч аймаг байхгүй гэхэд бараг хилсдэхгүй дээ. Тэгэхээр энэ дээр би энэ 2 асуудлыг асуумаар байгаа юм.

Дараагийнх нь энэ Байгаль орчны багц хууль гээд энэ байгаль хамгаалагчийн асуудлыг эд нар оруулж ирнэ гэсэн зүйлийг өмнөх сайд Одонтуяа сайд ярьж байсан. Тэгэхээр энэ асуудал ер нь ямар түвшиндээ байгаа вэ гэсэн 3 асуулт асууя.

Б.Бейсен: 4 номер хариулъя. Албан тушаалаа хэлээрэй.

Г.Энхмөнх: Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Энхмөнх. Идэрбат гишүүний асуултад хариулъя. Орон нутагт бол бид өнгөрсөн жил тухайлбал хог ангилан ялгах төвүүдийн жишиг зургийг хийгээд ингээд бүх аймгуудад хүргүүлсэн байгаа. Ингэснээрээ эхний ээлжид бид хэд дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ангилан ялгах энэ төвүүдээрээ бас ангилан ялгах ажлыг хийх зайлшгүй шаардлагатай.

Нөгөө талаасаа Хог хаягдлын тухай хууль болоод Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулиараа бид хэд 2017 онд нэмэлт, өөрчлөлт хийгээд энэ хуулийн өөрчлөлтөөр үндсэндээ тухайн аймаг, орон нутаг бол хог хаягдлын менежментээ өөрсдөө бүрэн хариуцаад хийх энэ бүх боломжийг нь нээж өгсөн. Энэ ч утгаараа яамнаас хог хаягдлын ангилан ялгах төв болоод тухайлбал сумуудад байгаа хог хаягдлын цэгүүд 1, 2, 3 дугаар зэрэглэл гэж байгаа. Энэ цэгийн жишиг зургуудыг мөн хийгээд ингээд бүх аймгуудад хүргүүлсэн байгаа. Энэ жишгээр бүх аймгууд тухайн хогийн 1, 2, 3 дугаар зэрэглэлийнхээ дагуу хогийн цэгээ байгуулаад, ингээд ангилан ялгах төвүүдээ байгуулаад явах бүрэн боломжтой байж байгаа.

Хоёрдугаарт нь тэр шатаах зуухтай холбоотой асуудал ярилаа. Бид 2022 онд Завхан аймгийн 5 сумд энэ шатаах зуухнуудыг өгсөн. Энэ хүрээнд яг ажиллаад явж байгаа зуухнууд болоод доголдож байгаа энэ асуудлууд байж

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байна. Өнгөрсөн жил бид бас энэ өнгөрсөн жил бид бас энэ нөгөө давхар шаталттай хог шатаах зуухнуудыг бол 2, 3 газар бол туршиж үзсэн.

Эхний ээлжид бид яамны шууд харьяанд байгаа Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанууд бол энэ хог хаягдлын менежментийг сайжруулах энэ ажлыг эхлүүлээд явж байгаа. Урьдчилсан байдлаар бид ямар ч байсан энэ 10 захиргаанд хог хаягдал пресслэх энэ төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгсөн. Яг одоогийн байдлаар бид Европын холбоотой хамтраад энэ Булган аймагт хэрэгжүүлсэн хог хаягдлын жишиг төвүүд гэж байгаа. Энэ дээр 330 сумаас 17 сумыг сонгоод ингээд сум болгон дээр 17 сум дээр эхний ээлжид бид хэд жишиг хог хаягдлын суманд хог хаягдал ангилан ялгах төв ямар байх ёстой юм, яаж хогоо ангилах юм, яаж landfill-ээ хийх юм гэдэг юм уу, энэ 17 сум нь бол сонгогдоод ингээд ажил нь эхлээд явж байгаа.

Тийм учраас энэ хэрэгжээд явж байгаа кейсүүдийг бусад сумуудад нэвтрүүлээд явна гэсэн байдлаар бид ажиллаад явж байгаа.

Б.Бейсен: 5 номер хариулах юм байна. Нэмж хариулах юм байна.

Ш.Батбаяр: Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбаяр байна. Багц хуульд Идэрбат гишүүний асуултад хариулъя. Байгаль орчны багц хуулийг боловсруулах ажлын хэсэг явагдаж байгаад Одонтуяа сайдын үед бас цаг үеийн шалтгаанаар зарим хуулиудыг түрүүлэн оруулж яаралтай батлах шаардлага гарсан учраас задлаад одоо 10 гаруй хуулийн үзэл баримтлал 70-80 хувийн гүйцэтгэлтэй, бусад хуулиуд нь үзэл баримтлал боловсруулах шатдаа явж байгаа.

Б.Бейсен: 3 номер Батбаатар сайдад нэмж яриулъя.

Б.Батбаатар: Нэмээд хариулчихъя. Энэ энгийн хог хаягдал шатаах зуух гээд зүйлүүд яригдаж байна. Хог хаягдлын тухай хуулийн 9.1, 9.1.3, 9.1.4, 9.1.5 гээд ингээд заалтууд байж байдаг. Тэгээд энэ заалтуудаар жишээлэхэд 9.1.3-д заасан энэ хог хаягдлыг дахин тээвэрлэх, боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг 21 аймгаас батлаад энэ 9 аймаг байж байгаа. Архангай, Ховд, Хөвсгөл, Дархан-Уул, Баян-Өлгий, Баянхонгор, Сэлэнгэ, Орхон, Дорнод гэсэн. 9.1.4-д заасныг нь бас батлаагүй 8 аймаг байж байдаг. Архангай, Дархан-Уул, Баян-Өлгий, Баянхонгор, Сэлэнгэ, Орхон, Дорнод, Өмнөговь гээд. 13 аймаг нь баталчихсан. 9.1.5-д заасан урамшуулал хог хаягдлын.../минут дуусав./

Б.Бейсен: 3 номер Батбаатар сайд нэмж хариулъя. 1 минут.

Б.Батбаатар: 9.1.5-д заасан жишээлэхэд хог хаягдлыг урамшуулал олгох тухай зүйл дээр Төв аймгаас бусад 20, 21 аймаг журмаа батлаагүй. Төв аймаг л ганцаараа тэр хог хаягдал дээр нь урамшуулал олгох журмаа баталсан. Тэгэхээр аймаг, орон нутгууд маань бас энэ тал дээр яг нөгөө Хог хаягдлын тухай хуулиараа хариуцаж авсан үүргүүдээ биелүүлэхгүй байгаа. Тэрнээс болж энэ хог хаягдлын асуудлууд үүсэж байгаа. Энэ дээр бас албан даалгавар болоод шийдвэрүүд яваад аймгууд маань бас ажиллахгүй байгаа.

Нөгөө талдаа Улаанбаатар хотын Нарангийн энгэр дээр 21 онд Ерөнхийлөгч Солонгос Улсад айлчлаад 100 хувийн буцалтгүй тусламжаар хог хаягдлыг нь

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

шатаагаад эрчим хүч үйлдвэрлээ гээд тэр төсөл тэр нь ингээд бэлтгэгдээд бэлэн болчихсон. Монгол тал газрыг нь өгөхгүй л байгаа юм байна лээ. Газрыг нь өгөхгүй болохоор нөгөө манайхаас ямар ч 1 төгрөг гарахгүй баригдах ёстой үйлдвэр 5 жил гацчихлаа гээд Фижи-д намайг Солонгосын талтай.../минут дуусав./

Б.Бейсен: Нийслэлээс бас асуусан уу? Уянгаа гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Өнөөдөр их чухал мэдээллийг сонсож байна. Бейсен даргад баярлалаа. Хог хаягдлын тухай хуультай холбоотой нэлээн олон асуудлууд, асуудлууд ч юу байх вэ дээ бид нар нэлээн их зүйлийг хийх ёстой байгаад байгаа. Тэгээд сая сайдын танилцуулгаас хэд хэдэн асуулт асууя. Олон яамны төлөөлөл ирсэн байгаа учраас бас асуултуудаа харж байгаад хариулаад өгөөрэй.

Сая танилцуулгад 2023-аас 24 онд нөгөө яг хог хаягдлуудынхаа гарал үүслийг нь судлаад үзэхээр эрүүл мэндийн салбарын үүсэж байгаа хог хаягдал нь болохоор 46, 47 хувиар буурсан гэж байх юм. Энэ яагаад тэгж байгаа юм бол? Нэг зүйл өөрчлөгдсөн юм болов уу?

Хоёр дахь сонирхож асуумаар байгаа зүйл нь дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нартай холбоотой юм. Хог хаягдлыг ялгах бол амархан асуудал байж магадгүй. Айл өрхүүд өөрсдөө хаяад ангилаад ангилаад, цаашаа очингуутаа тус тусдаа үйлдвэр рүү ордоггүй шүү дээ гэсэн асуудлууд их яригддаг юм байна лээ. Сая өнгөрсөн 25 оны, сая өнгөрсөн өвөл хаанаас билээ дээ албан бичиг манай ажлын албан дээр ирсэн байсан юм үйлдвэрүүдээс. Тэр албан бичгээ сая орж ирэхээсээ өмнө гаргаж ирж амжихгүй ороод ирлээ. Тэр дээр юу гэсэн байсан юм гэхээр түүхий эдээ, ангилсан түүхий эдийг тухайн үйлдвэр авч байгаа юм байна л даа. Авахдаа НӨАТ-ын баримт эд нарын асуудлууд үүсээд байдаг гээд. Тэгэхээр энэнтэй холбоотой ер нь ямар арга хэмжээ авдаг юм? Мэдээж хогоо, хогийг түүгээд, ангилаад, тушааж байгаа хүмүүс баримт гаргаж өгнө гэсэн асуудал бол байхгүй байх л даа. Тэгэхээр энэ үйлдвэрүүдийг хэрвээ дэмжье гэвэл энэ агуулга дээр юу хийх вэ? Аюултай хог хаягдлын устгалын асуудал гээд Сэргэлэн сумын нутагт тодорхой хэмжээний талбайг бол авчихсан байгаа юм байна. 25 онд нэгдсэн төв нь баригдаж эхэлнэ гэж ойлголоо. Их л удаан байгаад байх юм. Энийг бүгдээрээ юутай холбож ойлгох вэ? Хог хаягдлын тухай хуульд бас нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулж байгаа тухай мэдээлэл бас уншлаа. Агуулга нь ер нь хогоо үүсгээд байгаа үүсгэгч нь хариуцдаг байя, бохирдуулаад байгаа аж ахуйн нэгжүүд нь төлдөг байя гэж байгаа юм байна. Яг ямар заалт орох юм? Одоо байгаа 2017 оны хууль иймэрхүү л гэж ойлгоод уншаад байсан юм. Тэгэхээр мэдээж бас сайжруулах шаардлага байгаа байх. Тэр талаараа тайлбар хэлээд өгөөрэй.

Тэгээд энэ Хог хаягдлын тухай хуулийг дагаад Засгийн газрын 18 оны 116 дугаар тогтоолоор аюултай хог хаягдалтай холбоотой журам батлагдсан. Энд бол жагсаалт байгаа аж ахуйн нэгж салбар яамныхан бол жагсаалтаа бараг өөрсдөө гаргаж өгч бэлдсэн байгаа гэдэгт итгэлтэй байна. Энэ дээр ингээд бүх энэ хог хаягдлуудыг нь бүх олон салбар байгаа шүү дээ тээ эрүүл мэнд гээд энэ олон салбаруудаар нь ангилаад үзвэл 410 төрлийн хог хаягдлыг хүснэгтэлсэн байна. Тэрний яг дотор нь уншихаар хортой гэсэн заалттай нь 76 байна. Тэгэхээр яг бүх зүйлийг нэг журамд ингэж оруулах нь яг зөв үү, эсвэл яг зэрэглэлээр нь тус тусад нь авч үзээд тус тусад нь бодлого гаргаж зохион байгуулах ёстой юу?

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Б.Бейсен: 4 номер хариулъя.

Г.Энхмөнх: Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Энхмөнх. Эхний асуултаас нь эхлээд хариулъя. Тэр эмнэлгийн хог хаягдалтай холбоотой өөрчлөлт бол КОВИД-оос шалтгаалсан өөрчлөлт байгаа. Энэ дээр бид яг жил жилээр нь үзүүлэлтийг нь гаргаж үзсэн. Ингээд үндсэндээ 2023 онд бол өмнөх онуудтай харьцуулахад эмнэлгийн хог хаягдлын хэмжээ бол буурсан үзүүлэлттэй байгаа. Энэ маань бол шууд КОВИД-той холбоотой асуудал байж байгаа.

Хоёрдугаарт нь юу яаж байна, Хог хаягдлын тухай хуультай холбоотой асуултаа асуулаа. Хог хаягдлын хууль дээр бол бусад орнуудын хувьд бол И Пи Ар буюу үйлдвэрлэгчдийн өргөтгөсөн хариуцлага гээд байж байгаа юм. Тэгээд тухайлбал энэ нэгж бүтээгдэхүүн гаргахад нэгж бүтээгдэхүүний дахин боловсруулах зардал нь ямар байгаа юм. Тухайлбал яг орж ирж байгаа бүтээгдэхүүний хаягдал дугуй, дугуй гэхэд тэр дугуйны дахин боловсруулах зардал нь ямар байгаа юм. Энийгээ өөрөө байршуулж байгаад өөрсдөө дахин боловсруулах арга хэмжээгээ хийгээгүй бол мэргэжлийн байгууллагаар нь дахин боловсруулах арга хэмжээгээ хийгээд, зардал мөнгөө төлөөд явдаг ийм зарчим байж байгаа. Тэгэхлээр энийг бид хэд хийснээрээ тухайн томоохон үйлдвэрлэгч болоод ус, ундаа, архи пиво үйлдвэрлэж байгаа компаниудын хувьд бол энэ нэгж бүтээгдэхүүний сав баглаа боодлын тэр дахин боловсруулах зардлын асуудлыг нь бол шингээж өгснөөрөө буцаан таталтын асуудал, цаашлаад дахин боловсролтын асуудал бол нэг талдаа гарна гэж харж байгаа.

Тэгээд яг өнөөдрийн 2017 онд хийсэн шинэчилсэн найруулга дээр бол энэ үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын асуудлыг бол яг процессын нарийн тусгаж өгөөгүйгээс болоод хэрэгжихгүй ийм байдалтай л байж байгаа. Энэ хуулийн дараа 2018 онд Сангийн сайд болоод Байгаль орчин, уур амьсгалын сайдын хамтран баталсан журам байж байгаа. Энэ журмын хүрээнд хавсралтаар 11 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үүсгэгч нь өөрөө буцаад татах ийм журам байж байгаа. Энэ өөрөө нөгөө хуульчилж өгөөгүйгээс болоод өнөөдрийг хүртэл хэрэгжихгүй ийм байдалтай л байж байгаа. Ингэснээрээ үйлдвэрлэгчид бол нэгж бүтээгдэхүүнийхээ сав, баглаа боодлыг буцаан татах, дахин боловсруулах гэдэг юм уу энэ үүрэг хариуцлага бол маш сул байж байгаа.

Гурав дахь асуудал нь тэр та аюултай хог хаягдлын жагсаалт Засгийн газрын тогтоолоор баталсан юм байж байгаа. Тэр дээр мэдээж хэрэг яг харахаар бол тухайлбал шууд аюултай хог хаягдал гэж хэлэхээргүй асуудлууд байна гэж та хэллээ. Энэ нь өөрөө дахин боловсруулах гэдэг юм уу, дахин үйлдвэрлэлийн процесст ороод ингээд явахаараа хүрээлэн буй орчин болоод хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа ийм асуудлууд байж байгаа. Энийг бид Хими, хими технологийн хүрээлэн болоод бусад шинжлэх ухааны академи болоод бусад судлаачидтай хамтарч гаргасан байж байгаа. Тэгээд энэ дээр бид зайлшгүй Базелийн конвенцтой холбоотойгоор энэ листийг дахин шинэчлэх, нэмж оруулах ийм зайлшгүй шаардлага байгаа. Тэгээд эхний ээлжид бид ямар ч байсан энэ ондоо Хог хаягдлын тухай хуульдаа өөрчлөлт оруулъя, энэ дээрээ тодорхой процессуудаа тусгаж өгье, үүний дараа бол Засгийн газрын тогтоолоор батлагдсан листэдээ бол өөрчлөлт оруулъя гэсэн ийм төлөвлөгөө гаргаад ажиллаж байгаа.

Б.Бейсен: 4 номер нэмж хариулъя. 4 номер нэмж хариулъя.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Г.Энхмөнх: Аюултай хог хаягдлын байгууламжийн асуудал та асууж байна. Газрын асуудал шийдэгдэхгүй үндсэндээ 3, 4 жил явсан. Энэ дээр яг нөгөө тусгай хэрэгцээнд авахын тулд сум болоод аймгийн Иргэдийн хурлаараа ордог юм байна лээ. Ингээд энэ асуудлыг бид ямар ч байсан нөгөө урьдчилсан тэр байгаль орчны нөлөөллийн суурь судалгааг нь хийлгээд энийгээ яг тухайн сум болоод аймгийн иргэдийн хуралд нь танилцуулаад ингэснээр нөгөө газрын асуудал нь шийдэхгүй удсанаас болоод л ингээд л удааширч байгаа. Энэ өөрөө 2015 онд ТЭЗҮ урьдчилсан үзүүлэлт нь байж байгаа.

Ингээд бид ямар ч байсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиараа бүрдүүлэх бичиг баримт гээд байдаг юм байна лээ. Энэ хүрээнд нь бид хэд урьдчилсан тэр эдийн засгийн үзүүлэлтүүдийг нь хийгээд ингээд Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн байж байгаа. Таны түрүүний бас дурдсан тэр нөөцтэй холбоотой асуудал асууж байна. Энэ яг дахин боловсруулах үйлдвэрүүдийн хувьд бол нэн чухал асуудал байж байгаа. Тухайлбал, дахин боловсруулах дахивар бүтээгдэхүүнийг нийлүүлж байгаа цуглуулаад өгч.../минут дуусав./

Б.Бейсен: Уянгаа гишүүн тодруулъя. 4 номерт гүйцээж яриулчих.

Г.Энхмөнх: Энэ дахивартай холбоотой НӨАТ-ын асуудал гээд энэ хамгийн хүнд асуудал байж байгаа. Хог хаягдлын хуулийг дагаад 6 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал явж байгаа. Яг энэ дээр таны хэлээд байгаа тэр НӨАТ-тай холбоотой асуудал мөн орчихсон явж байгаа. Ингээд бид Хог хаягдлын тухай хуулиа дагаад ингээд хамтад нь өргөн барина л гэсэн үг.

Б.Бейсен: Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Хог хаягдлын менежмент маш чухал асуудал байгаа. Зүгээр нэмж мэдээлэл өгөхөд саяхан бас парламент суудалтай 5 намын төлөөлөл Дани улсад туршлага судлаад ирсэн. Тэр нь ямар зорилготой байсан бэ гэхээр Дани улсын парламентад суудалтай Грийн лифт болон Социал демократ гээд 2 улс төрийн нам нь нийлээд Монгол Улсын бас энэ парламенттай хамтраад олон намууд нийлээд ямар нэгэн үр дүнд хүрдэг гэдгийг харуулах зорилгоор ийм платформ үүсгэчихсэн. Тэгээд тэр платформынх нь сонгосон энэ удаагийн туршилтын төслийнх нь сонгосон сэдэв нь хог хаягдлын менежмент. Мэдээж 5 намын төлөөлөл намынхаа гишүүдтэй яваад ирсэн. Дани улс бол үнэхээрийн өндөр түвшинд хөгжчихсэн, хогоо 10 янзаар ялгадаг. Ялгасан хог хаягдлаа маш их ийм дахин үйлдвэрлэлд оруулж боловсруулдаг. 3, хог хаягдлын 3-хан хувиа газарт булдаг ийм орон байна. Тэгэхээр Монгол Улсын хувьд бол ядаж бага зэргийн ч болтугай ахиц дэвшил гарахгүй бол үнэхээрийн хоцрогдлоо. Нөгөө талдаа нөгөө агаарын бохирдлоос гадна хөрсний болон хог хаягдлын бохирдол чинь нэвт явах нь гэдэг ийм хүнд асуудлууд байгаа.

Гэтэл энэ асуудлыг ухамсарлаад иргэд уг нь хог хаягдлаа ангилаад байдаг хогийн машин нь ирээд буцаад холиод аваад явчихаар чинь тэр нөгөө өрхүүд 61 хувийг үйлдвэрлээд байгаа тэр өрхийн хог хаягдал чинь ямар ч ийм урамгүй болчихож байгаа байхгүй юу. Ялгаад буцаад холилдох юмыг ялгахгаар бараг утгагүй байгаа биз дээ яаж ч бодсон. Энэ асуудлыг үтэр түргэн шийдэх шаардлагатай байна гэж харж байгаа юм.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хоёрдугаарт миний асууж байсан тэр үйлдвэрлэгч нь хариуцлага хүлээдэг, бохирдуулагч нь төлдөг байя гээд. Тэрийг бол нарийн бас харах хэрэгтэй юм байна лээ. Байгаль орчны яам дээр үүссэн тэр ажлын хэсгийн боловсруулж байгаа хуулийн төслийг бол харсан. Ажиллах шаардлага бол байна гэж бас бодсон. Тэгээд энэ асуулт болохоор ингэчихсэн байна шүү дээ. Жишээлбэл, энд хар аюултай хог хаягдлын дийлэнх нь 2024 оны, 20 оны байдлаар нэмэлт аюултай хог хаягдлын 76.7 нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас, 21.4 хувь нь цахилгаан станц дулаанаас гэснээ 23 онд болохоор 36.1 болж буураад, эмнэлэг, эрүүл мэнд, 43.3 нь цахилгаан станц дулаан, харин 20.1 хувь нь уул уурхайн ажиллагаанаас үүссэн байна гээд.

Тэгэхээр миний хувьд энд бол ангиллын асуудал байна гэж харж байна. Уул уурхай гэв гэнэт 23 онд гараад ирээгүй юм чинь энэ яг алдаа байна. Дата-гаа сайн харах, өглөө зөв цуглуулах, анализ хийхэд ийм гэнэтийн, цочирдом, утгагүйдүү тоонууд байхаар чинь анализ хийж цаашдаа шийдэл гаргахад хэцүү шүү дээ. Энэ дээрээ хариулт, тодруулга авъя. Тэгээд одоог хүртэл яг юу хийж ирэв ээ? 2017 оноос хойш түрүүний 4 жилийн парламент ч гэсэн гишүүд маш олон улсаар явж туршлага энэ тэр судалсан юм байна шүү дээ. Тэгээд яав юу нь болохгүй байв? Нэгд тэр талаар базаж сонсьё гэж бодлоо.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 4 номер хариулъя.

Г.Энхмөнх: Тэр хувь, хэмжээтэй холбоотой асуудал асуулаа. Тэгээд шаардлагатай бол бид хэд бүүр дэлгэрэнгүй мэдээллийг нь өгье. Бидэн дээр юу гэдэг юм яг үүсгэгч 2800 аж ахуйн нэгжээс ирүүлсэн бүх дэлгэрэнгүй мэдээлэл нь байж байгаа. Энэ хүрээнд бол яг дотроо ангилалтай уул уурхай, эрүүл мэнд ингээд, бусад салбарууд нь бол нэг бүрчлэн байж байгаа юм. Тэгэхлээр эндээс шаардлагатай бол бид хэд бүр энэ 2800 аж ахуйн нэгжийн дэлгэрэнгүй мэдээллийг танд бас албан бичгээр хүргүүлье.

Ингээд энэ дээр бол тооны хувьд алдсан зүйл бол байхгүй. Энэ дээр бол би шалтгаан, нөхцөлүүдийг нь бол бүрчлэн бичсэн байгаа. Эмнэлгийн хог хаягдлын хувьд бол мэдээжийн хэрэг тэр КОВИД-той холбоотой асуудал, нөгөө талаасаа КОВИД-ын үед бол энэ уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа болоод энэ нөгөө консалтинг компаниудын үйл ажиллагаа бол тасалчихсан ийм асуудал бол байгаа. Энэ дээр бол бид хэд бүүр хэчнээн аж ахуйн нэгж ажилласан байна, ажиллаагүй байна гэдэг юм уу энэ бүүр нарийн тоон мэдээлэл нь бол байж байгаа.

Хоёр дахь 2017 оноос хойш яам юу хийсэн бэ гэдэг асуудал байна. Энийг би танд бас тоймлоод асуудлыг нь ярья. Бид ямар ч байсан энэ хугацаанд аюултай хог хаягдлын түр байгууламжуудыг бол аймаг болгонд ингээд үүсгээд явж байна. Энэ ажил бол үндсэндээ эхний ээлжид бол 5 аймагт байгуулчихсан, одоо яг баригдаад явж байгаа нь 10 аймаг байна гэх мэтчилнээр бид хэд ямар ч байсан эхний ээлжид энэ аюултай хог хаягдлын нэгдсэн байгууламж, ашиглалтад орох хүртэл л энэ аюултай хог хаягдлаа бол түр хадгалах байгууламж сүлжээг нь бий болгоё. гэдэг энэ асуудлууд хийгээд явж байгаа. Энэ хүрээндээ бид хэд аюултай хог хаягдлын түр хадгалах байгууламжийн жишиг зургийг хийлгэсэн. Мөн энэ аймгийн төвүүдэд ангилан ялгах боломжтой хог хаягдлыг ялгахтай холбоотой асуудлаар бид хэд ангилан ялгах жишиг төвийн зургийг мөн батлуулаад ингээд аймгуудад хүргүүлсэн.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хоёрдугаарт нь энэ юу байж байна, энэ нөгөө сумын төвийн хог хаягдлын цэгийн байршилтай холбоотой асуудлаар бид дүн шинжилгээ хийж үзсэн. Ингээд харахад бол нийт хог хаягдлын байршлын 40 орчим хувь нь бол салхин дээрээ, нөгөө талаасаа суурьшлын бүстэйгээ хэт ойрхон. Мөн энэ дээр нөгөө гол мөрний урсац бүрэлдэх эх болоод энгийн болон онцгой хамгаалалтын бүсүүд дээр байсан суурьшмал болон өнжмөл энэ хог хаягдлыг бол өнгөрсөн жил бид 200 орчим га талбайд бол цэвэрлээд дууссан байж байна.

Нөгөө талаасаа хог хаягдалтай холбоотой асуудал дээр та ярьж байна. Ямар жишиг байна, ямар зохицуулалт байна гэж байна. Одоо бид шинэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөрөө бол илүү ТҮК гэхээсээ илүүтэйгээр энэ хувийн хэвшил менежментийг хариуцуулах энэ чиглэл рүү явж байгаа. Тэгээд төр өөрөө бүгдийг нь хариуцаад байхаасаа илүүтэйгээр хувийн хэвшил, мэргэжлийн байгууллага, холбоотын оролцоог оруулах нь бол нэн шаардлагатай. Мөн түрүүнд сайдын танилцуулсан асуудлууд байж байгаа аймаг, сумууд маань журмаа батлахгүй байна. Энэ журам дээр юу гэхлээр нөгөө урамшууллын журам байж байна. Хог хаягдлын тариф байж байна. 330 сумаас өнөөдрийн байдлаар 100 орчим сум өөрөө хог хаягдлын тарифаа баталгаагүй ийм л байдалтай байж байгаа.

Тэгэхлээр энэ нөгөө 2017 оны хуулиараа нутгийн захиргааны өөрөө удирдах байгууллагад өгсөн эрх үүрэг байж байгаа. Энийгээ биелүүлэхгүйгээс болоод энэ төлбөр, хураамж төлөгдөхгүй, урамшуулал олгогдохгүй ийм байдалтай л байгаа. Тэгээд ямар ч байсан энэ дээр түрүүн сайд хэлсэн бид ямар албан даалгавар гаргаад хугацаатай аймгуудад бол хүргүүлчихсэн байж байгаа.

Б.Бейсен: Мөнхсоёл гишүүнд тодруулъя.

Б.Мөнхсоёл: Манай 4 номер чинь хэн гэж хүн билээ айн? Миний асуултыг ерөөсөө ойлгоогүй баахан ярьчихлаа. Нэгдүгээрх нь яагаад гэнэт уул уурхайн салбарын хог хаягдал гараад ирэв? 23 оноос өмнө нь өөр ангилалд байсан уу тэрнээс биш эрүүл мэндийнх огцом буураад нөгөөдүүл буураад энд уул уурхайн хог хаягдал 23 оноос үйлдвэрлэж эхлээгүй байх гэдэг л логик асуулт байсан. Ганцхан өгүүлбэр хариулах. Хоёрт, тоон дээр алдсан гээгүй. Наадах чинь логикийн алдаа байна л гэсэн.

Хоёрдугаарт нь болохоор хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах гээд байгаа шүү дээ. Бодит амьдрал дээр асуудал байна. Ямар сайндаа би өөрөө түрүүн хэлчихлээ шүү дээ айл өрхүүд тэр 61 хувийн хог хаягдлыг гаргаад байгаа тэр хүмүүс маань зарим нь ухамсраараа хогоо ангилаад байдаг ачих машин нь холиод аччихаар чинь яаж юм цаашаа явах вэ гээд. Би эв энгийн энэ сэдвээр бүүр судалгаа хийгээгүй 10 жилийн хүүхэд хэлэхүйц юмыг жишээлээд тэгээд.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер Энхмөнх дарга хариулъя.

Г.Энхмөнх: Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Энхмөнх. Энэ юу яасан юм гишүүн ээ энэ хог хаягдлын мэдээлэл цуглуулах, боох маягт гээд байдаг юм. Маягтаа бид хэд шинэчилсэн, тэгээд нөгөө ангиллаа илүү нарийвчилсан. Тэрэнтэй холбоотой бас энэ нөгөө өөрчлөлт нь өөр харагдаж байх шиг байна. Аанхан. Хог хаягдлын тухай тийм хуультай холбоотой асуудлаар бид өмнө нь бол нөгөө Байгаль орчны багц хуулийг хууль дээр бол Хог хаягдлын тухай

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хууль явж байсан. Ингээд багц хууль буцаад татсанаар бид хэд Хог хаягдлын тухай хуулиа бол дангаар нь ингээд одоо яг боловсруулаад үзэл баримтлалын шатдаа явж байгаа гэсэн үг.

Б.Бейсен: Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр энэ хог хаягдлын асуудал бас тулгамдсан асуудал. Хаа сайгүй л хог. Тэгээд үүнийг устгадаг барьдаг, ангилдаг, боловсруулдаг тийм юм байхгүй байна шүү дээ. Энэ Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэх гол үүрэг бүхий газар нь танайх зохион байгуулах, боловсронгуй болгох. Тэгээд би уг нь бичиг өмнөх сайдыг байх үед явуулж байсан. Надад энэ Хог хаягдлын хууль ямархуу хэрэгжилттэй байна вэ гээд тэгсэн надад ганцхан хуудас хариулт ирсэн юм. 25 оны энэ чинь 5 сарын 12 гэж байх шив дээ. Тэгээд ганцхан хуудас. Бүхэл бүтэн энэ том хуулийн хэрэгжилтийг 1-хэн хуудаст багтаагаад салбарын хяналтын газрын дарга Мөнхтогтох гэдэг хүний гарын үсэгтэй ийм л улсын хэмжээнд хэрэгжиж байгаа Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилт гэсэн чинь А4-ийн цаас нь багтсан ийм л юм. Энийг нь уншихлаар 1 тэрбум 30 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч зөрчлийг үр дагаврыг арилгуулсан гэсэн л юм байгаа юм. Тэгээд өөр юм байхгүй.

Тэгэхээр танайх чинь тийм торгодог л ажил хийдэг юм уу Хог хаягдлын хуулийг хэрэгжүүлэх хүрээнд? Өөр энэ дээр хийсэн юм байхгүй байгаад байгаа байхгүй юу. Энд бид нар асуусан болоод та бүхэн хариулсан болоод ингээд цаг нөхцөөх ч яах вэ. Энэ чинь яг байдал дээрээ бол энэ хог гэдэг юм чинь дийлдэхээ больчихсон байна шүү дээ. Сумын сум болгоны салхин доод зүүн урд талд нь хог нь хийссэн замбараагүй ил задгай. Аймаг болгонд ийм нүх хонхойлоод тэгээд хогоо асгаад шатааж утаа суунагласан байдалтай үхэр, мал холилдоод очоод бутраасан байдалтай. Аялал жуулчлалын байгалийн үзэсгэлэнтэй газрууд нь дүүрэн хог, цаас, лааз, шил. Тэгээд л энэ Улаанбаатар гээд ер нь хоггүй тийм газар гэж байхгүй. Хогны тухай ер нь хийж байгаа юм манай улсад алга байна шүү дээ. Нэг ч боловсруулдаг үйлдвэр, ялгаж байгаа нэг ч айл, албан байгууллага байхгүй.

Тэгэхлээр үүнийг яах ёстой юм, юундаа байгаа юм. Хууль, эрх зүйн орчин нь болохгүй байгаа юм уу, зохион байгуулалтын асуудал байгаа юм уу, төсөв хөрөнгийн асууд л байгаа юм уу та бүхэн хэлээдхээч. Яах ёстой юм? Энэ уул уурхай гээд л миний сайн мэдэх Өмнөговь, говийн бүсээр дүүрэн уурхай, дүүрэн хог. Эргэн тойрон тэгээд л тэр уурхай хашаан дотор ч хог, гадаа нь ч хог. Тэгээд л ойр хавийн малчин айлуудын хороо буучихсан сүүлдээ хаягдал уул уурхайн хаягдсан, хагарсан дугуйны л юу боллоо шүү дээ агуулах болж хувирлаа. Тэгээд л машинаас гарсан сэлбэг хэрэгсэл, тостой алчуур бүгд ингээд л байж л байна устгагдахгүй байгаад л байна. Тэгээд энийг яах ёстой юм?

Б.Бейсен: 2 номер хариулъя.

Б.Мөнхтогтох: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгаль орчны улсын хяналтын газрын дарга Мөнхтогтох. Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Бид нар хог хаягдлын тухай хуулийнхаа чиг үүргээр бол бас аюултай хог хаягдал болон энгийн хог хаягдлын асуудал дээр бол хяналт шалгалт тавих ийм чиг үүрэгтэй байгаа. Гэхдээ Хог хаягдлын тухай хуульд зааснаар Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн асуудал нь бол бас салбар

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дундын асуудлууд байдаг. Тухайлбал, Хог хаягдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 6, 7, 8-д заасны дагуу харьяалах асуудлаар буюу эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаанаас үүсэж байгаа хог хаягдал дээр эрүүл мэндийн салбар, уул уурхайн төслийн үйл ажиллагаанаас үүсэж байгаа хог хаягдал дээр Уул уурхайн яам, барилгын хог хаягдалтай холбоотой асуудал дээр ингээд Барилга, хот байгуулалтын яамнаас ингээд салбарын үндсэн хяналтуудыг тавих үндсэн зохицуулалттай. Манай яамнаас бол ингээд энгийн хог хаягдал, аюултай хог хаягдал, химийн бодисын аюултай хог хаягдлын чиглэлээр бол жил бүр хяналт шалгалтыг тавьж байгаа. Хяналт шалгалтыг тавихдаа бид нар Засгийн газрын хуралдаанаар болон Хяналт үнэлгээний үндэсний хороогоор бол урьдчилан сэргийлэх хяналт шалгалт болон төлөвлөгөөт хяналт шалгалтуудыг батлуулдаг байгаа.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтынхаа хүрээнд бол 1 чиглэл дээр нь бол хог хаягдлын асуудлыг бол тусгайлан авч үзээд салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн хүрээнд бол улсын хэмжээнд бол хяналт шалгалтыг тавьж ажиллаж байгаа. Мөн төлөвлөгөөт бус иргэдээс, иргэд болон байгууллага, аж ахуйн нэгжээс холбогдох байгууллагуудаас ирсэн санал, хүсэлтийн хүрээнд бол төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд бол хог хаягдалтай холбоотой асуудлыг, мөн төсөл хэрэгжүүлэгч, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээр ийм төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд бол тавьж байгаа хяналт, шалгалт дээр бол хог хаягдлын асуудлуудыг бол тавьж ажиллаж байгаа. Тэгээд гишүүдийн тавьж байгаа асуудлууд бол үндэслэлтэй байна.

Тухайлбал, ингээд аюултай хог хаягдлын асуудал ярихаар бид нар бол зөвхөн Засгийн газраар энэ чиглэлээр хяналт шалгалт хийнэ. Тэгээд Ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн хүрээнд гэлгүйгээр яг аюултай хог хаягдлын эх үүсвэрийг үүсгэж байгаа байгууллага аж ахуйн нэгж нь эх үүсвэр нь хэд байна вэ гэдэг агуулгаар нь бол нэлээн үндэслэлтэй хяналт шалгалтуудыг хийдэг байгаа.

Тухайлбал, Улаанбаатар хотын хэмжээнд хэдэн тээврийн хэрэгсэл явж байна. Тээврийн хэрэгслээс бол тос тосолгооны материалыг бол жилд ингээд 2 удаа солиход хэдий хэмжээний аюултай хог хаягдлын үүсгэнэ вэ? Энэ дээр бол манай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас зөвшөөрөл авсан байгууллага аж ахуйн нэгжүүд нь хэд байна? Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч компаниуд хэд байна, энэ дээр ашиглагдаж байгаа техник тоног төхөөрөмжийн тоо нь хэд байна, эндээс үүсэх аюултай хог хаягдлын асуудал хэд байна гэдэг ийм судалгаа, мэдээллүүдийг аваад энэ дээрээ чиглэсэн хяналтуудыг бол тавьж байгаа.

Тэгээд аль тухайлбал уул уурхайн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж ихтэй аж ахуйн нэгжүүд рүү тухайлбал Өмнөговь аймаг руу байна уу ингээд илүү тийм хүчтэй эрчимжүүлсэн хяналт шалгалтыг бол хэрэгжүүлэхийг үүрэг болгодог. Энэний хүрээнд бол хяналт шалгалтын дүнг нэгтгээд, нэгтгэсэн асуудлаар, тулгамдаж байгаа асуудлуудаар бол холбогдох яамд болон хүрээлэн буй орчин, бодлого, зохицуулалтынхаа газар руу бол асуудал тавиад холбогдох эрх зүй, хууль, эрх зүй, журам дээр бол өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлуудаар бол хяналт шалгалт тавьж ажилладаг байгаа.

Б.Бейсен: Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Хяналт шалгалт л баахан ярьж байна. Үнэндээ хяналт шалгалт гэж байхгүй болсон шүү дээ. Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газраа татан буулгаад тэгээд дураараа дургиж дунд чөмгөөрөө жиргэх эхлэл маань тавигдаад одоо бол сайхан замбараагүй явж байгаа. Монгол Улс хяналт шалгалт байхгүй. Яамнууд руу нь өгсөн. Нэг гараараа тусгай зөвшөөрөл өгчхөөд нөгөө гараараа хяналт шалгалт хийнэ гэж ямар юм байх вэ дээ. Хяналт шалгалт гэдэг чинь хөндлөнгийн юм байж байж л хянахыг хэлж байгаа шүү дээ. Тэгээд баахан л ярих юм хяналаа шалгалаа гээд. Өнөөдөр яг бодитой амьдрал дээр чинь тэр уул уурхайн хашаан дотор чинь уул овоо шиг болчихсон дугуйнууд байна шүү дээ. Үгүй тэрийг чинь та нарыг хүлээгээд ямар заавар, чиглэл өгөх юм, ямар стандарт өгөх юм хүлээгээд байгаад байх юм? Тэр нь бүр хашаанаасаа багтахдаа байгаад тэр хөдөө хээрээр хүртэл олон дугуйнууд. Тэр тостой алчуур тэр машины сольсон тэр юунууд байна шүү дээ агаар шүүгчид тэр чинь бүгдээрээ овоороод савандаа багтахдаа больчихлоо шүү дээ. Энийг яах юм яг тодорхой? Яах ёстой юм эд нарыг?

Б.Бейсен: 4 номер хариулъя.

Г.Энхмөнх: Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Энхмөнх. Хог хаягдал дахин боловсруулах өнөөдрийн байдлаар 84 үйлдвэр байж байна. Үүнээс 26 нь бол аюултай хог хаягдал дахин боловсруулах. Таны ярьж байгаа хаягдал дугуйтай холбоотой асуудал ярьж байна. Хаягдал дугуй дахин боловсруулах үйлдвэрүүд мөн байна. Өнөөдрийн байдлаар ажиллаж байгаа хаягдал дугуй дахин боловсруулах 4 үйлдвэр байж байна. Эндээс бол 2 нь Цогтцэций, Ханбогд хоёрт байж байгаа. Ингээд үндсэндээ яг стандарт нь байж байна, үйлдвэрүүд нь байж байна. Яг газар дээрх хяналт, шалгалт хяналт тавих хүмүүс маань бол аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга, тухайн Байгаль орчны газар, салбарын хяналтын газар гээд ингээд бүх шат шатандаа байж байгаа. Энэ дээр яг стандарт байна уу байна, дахин боловсруулах үйлдвэр байна уу байна. Гол нь ерөөсөө яг таны хэлж байгаа газар дээрх хяналт шалгалттай холбоотой л асуудал байгаа.

Б.Бейсен: 3 номер сайд нэмж яриулъя.

Б.Батбаатар: Манай гишүүдийн хэлээд асуугаад байгаа зүйлүүд үнэн үнэн. Хаа сайгүй л хог байж байгаа. Гараад л 3 алхахгүй хог байж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр бид нар нэг зүйл анхаармаар байгаа юм. Яг энэ Байгаль орчны багц хуулийг ер нь багцлаад нэлээн томоохон хэмжээнд бодож өөрчлөхгүй бол энэ хууль багц хууль өөрчлөгдсөнөөс хойш 10 гаран жил болоод хугацаа алдаад ер нь хуучирсан талууд бий. Өмнөх Засгийн газрын үед бол энэ багц хууль явж байсан багц хуулиа олон жижиг таслаад ингээд бэлдчихсэн. Тэр хуулиудын төсөл дээр нь үзэхэд зарим хуулиуд нь бол ерөөсөө болохооргүй байгалийнхаа эсрэг хуулиуд болчихсон байсан. Тэгээд ажлын хэсгүүд нь ажиллаж байгаа. Дахиж сайжруулж ажиллахаас өөр замгүй болсон.

Байгаль орчны салбар бол одоо яг үнэндээ хохирогч нь юм байгаа юм. Хохироогч нь барилга, хот, уул уурхай, зам тээвэр, аялал жуулчлал, агаар, энэ агаар орчныг бохирдуулж байгаа энэ салбарууд чинь бүгдээрээ эд нар.../минут дуусав./

Б.Бейсен: 3 номер сайд нэмж яриулъя.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Б.Батбаатар: Тэгээд яг үнэндээ бид нар ингээд ойлгохоороо бүгдээрээ нэг зүйлийг ойлгочихдог. Агаарын бохирдол ярихаар байгаль орчинтой ярьдаг, хог ярихаараа байгаль орчинтой ярьдаг. Хууль дээрээ болохоор тэр агаарын бохирдол, тэр хог, энэ цэвэрлэгээ үйлчилгээ, тэр бүх юм нь уул уурхай, барилга, хот байгуулалт, зам, тээвэр, засаг захиргааны нэгж, аймаг, дүүрэг, сум гээд ингээд явчихсан байж байдаг. Нүүрс олборлолоо гэхэд тэндээс тонн тутамд орж ирж байгаа орлогыг тэр чигээр нь 70-аад тэрбум байх би яг нарийн тоог нь санахгүй байна. Улаанбаатар хот руу орж байдаг. Үүссэн хогийг нь болохоор Байгаль орчны яамтай ярьж байдаг. Агаар бохирдлоо Байгаль орчны яам. Энэ чинь Зам, тээврийн яам, тэр хотын засаг захиргаа, хохирогч нар нь эд нар байхгүй юу эрчим хүч эд нар. Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлт дээрээ энийгээ нэлээн сайн хийж авч байж бид нар энэ чадавх чадамжийг нэмэхгүй бол өнөөдөр хамгийн бага төсөвтэй, хамгийн хүн хүч дутуу байгаа газар нь бол манай.../минут дуусав./

Б.Бейсен: Сайд нэмж хариулах уу? 3 номер. Болсон юм уу?

Энэ манай Байнгын хорооноос энэ хог хаягдлын асуудлаар Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар ингээд юм сонсож байгаа. Яах аргагүй манай улсын хэмжээнд тулгарсан асуудал болчхоод байгаа юм. Мэргэжлийн хяналт талыг тараачихсан, хяналт байхгүй, байцаагч нар яамнуудаар өгчихсөн, конторт суудаг жинхэнэ ажлын талбар дээр очоод хяналт хийдэггүй ийм л улсууд болчхоод байгаа юм. Энэнтэй холбоотой тулгараад байгаа нэг асуудлуудыг ярьж гэж бодож байна. Энэ энгийн хог хаягдал, нөгөө талаараа энэ аюултай хог хаягдал, эмнэлгийн хог хаягдлын асуудал байж байгаа. Арьс ширний үйлдвэрийн хог хаягдал, арьс ширний ихэнхдээ хром хэрэглэдэг та бүгд мэднэ. Хром чинь хөгшрүүлэх үйлчилгээтэй каллогенийн нэгдэл шүү дээ. Энийг хаанаас авчирдаг юм?

Нөгөө талаар эмнэлгийн хог хаягдал Мөнхсайхан сайд сайн мэдэж байгаа байх хотын клиникийн эмнэлгүүд дээр гарч байгаа хог хаягдал хараарай. Шприц, хагалгааны материал бүх юм хаягдаж байгаа. Мөн энэ түрүүн ярьж байна аккумуляторын үйлдвэр, үйлдвэр гээд хотын хэмжээнд бүх аккумуляторыг цуглуулдаг, тэр гис...-гийн асуудал байж байна химийн. Дахин боловсруулах үйлдвэр байхгүй. Батбаатар сайд 3 сар л болж байна ажиллаад. Сайн танилцаж чадаагүй байх. Энэ дээр анхаарлаа хандуулаад та ер нь энэний хойноос орохгүй бол.

Нөгөө талаар энэ Хөдөө аж ахуйн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар энэ араас орохгүй бол ерөөсөө хог хаягдал дэндчихсэн. Ялангуяа энэ барилга хөгжөөд, техник хэрэгсэл ихсээд ингэж байгаа үед барилгын хог хаягдал энэ Барилга, хот байгуулалтын яамнаас хэчнээн төрлийн хог хаягдал хэчнээн тонн мянган тонн хог хаягдал хаягдаж байна. Хотын засварыг та бүхэн харж байгаа. Энийг хаана устгаж байна нэгдүгээрт энийг асууя.

Хоёрдугаарт, энэ Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийнхнээс асууя. Эмнэлгийн хог хаягдлыг хаана устгаж байна, дахин боловсруулах үйлдвэр барьсан уу? Энэ хэдэн жилийн өмнө эмнэлгийн хэрэглээд хаясан бээлийг угааж дотор нь талк хийгээд дахиж савлаад зараад баригдсан нь асуудал гарсан. Энэ маш ноцтой, аюултай асуудал юм байгаа юм. Бүр хөдөөгийн эмнэлгүүдийн тендер

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нөхчихсөн асуудал гарсан. Тэгэхээр энд хяналт хийж чадаж байна уу, дахин боловсруулах үйлдвэр байна уу? Мөн Хөдөө аж ахуйн яамны мал нядалгааны газрууд байж байна. Асгаж хаядаг, газар ухаад булдаг, тэгээд дулаарахаараа тэр нь нөгөө ялзраад ялаа гардаг ийм асуудал, халдварт өвчлөл ийм асуудлууд байж байгаа.

Мөн энэ Ховдынхоос хүсэлт ирсэн Буянт голын эх хог хаягдлаар бохирдож байна гэдэг асуудал тавьсан. Би тухайн үед Одонтуяа сайдад албан бичгийг нь явуулсан. Төсөв хуваарилсан гэсэн. Энд хэчнээн төгрөгийн төсөв хуваарилсан юм? Тэгээд би сая хүн явуулаад үзүүлсэн чинь зүгээр хогийг нь бөөгнүүлээд хаячихсан байна гэнэ ээ. Буянт голын эх нь Баян-Өлгийн Дэлүүн сумаас их явдаг юм байна. Ховд хотын иргэд тэр ус бохирдож байна гэсэн хүсэлт ирүүлсэн.

Нөгөө талаар энэ Байгаль орчин, аялал жуулчлалын яамныхан байна уу? Энд Ховд голын жуулчид гялгар уут, пластик сав хийсээр байгаад Хар ус нуурын доор тунаад ерөөсөө замгыг устгах загасны устах аюулд хүрч байна гээд тийм асуудал гарч байна. Ийм юман дээр судалгаа хийсэн юм уу? Дараа нь энэ аккумуляторын асуудал байж байна. Түрүүн Дарханы тэр юуны тийшээ Рашаан булаг билүү ямар газар телевизээр гарч байсан. Тэнд үйлдвэр байгуулсан шингэнээ асгадаг. Рашаан бохирдуулж байна гэж байна. Энэ талын судалгаа хийж үзсэн юм уу? Нөгөө талаар уул уурхай хөгжсөн байхад ингээд моторын хаягдал тос уурхайнуудын хотын хэмжээний бүх засварын газрууд байж байна. Аймгуудын засварын газрууд байдаг юм. Энэ дээр энэ аюултай хог хаягдал хариуцсан мэргэжилтэн энэ Улаанбаатар хот, аймгууд уурхайнууд хэчнээн тонн аюултай хог хаягдал хаягдаж байна. Энэ судалгаа гаргасан уу? Уурхайнуудаас бид нар мэдээлэл авсан. Газар ухаж байгаад плёнк тавьж байгаад тэнд асгаад дахиж булдаг юм байна.

Гэтэл энэ дахин боловсрох үйлдвэр барьсан байна. Налайхын Городок дээр хаягдал тос боловсруулах. 100 тонн хаягдал тосыг боловсруулаад 70 тонн дизелийн түлш гаргаад 30 тоннд нь нөгөө битүүм, замыг нь битүүм болгодог юм байна. Гэтэл энийг хавчаад нөгөө зөвшөөрлийг нь олгодоггүй гэнэ ээ. Налайхыгаа хаачихсан нөгөөх нь нөхөн төлбөр нэхэж байгаа. Тэгээд Сэргэлэн сумын нутгаас газар олгосон байна. Ийм юмыг дэмждэггүй манайхан ерөөсөө. Сая Наранбаатар гишүүний ярьдгаар зүгээр газар ухаад булаад л бол оо.

Сангийн яамнаас асуух юм энэ урамшуулал энэ төсөв байдаг уу? Аймгууд дээр хэчнээн төгрөгийн төсөв тавьдаг юм? Эрүүл мэндийн яам хэчнээн төгрөгийн тэр эмнэлгийн хог хаягдлын урамшуулалд мөнгө олгодог юм тэр талын энэ асуудлын дараа асууж дараа нь тодруулъя.

Эхлээд Байгаль орчны яам 4 номер.

Г.Энхмөнх: Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Энхмөнх. Аюултай хог хаягдлын 26 үйлдвэр байгаа дахин боловсруулах. Үүнээс хаягдал тос дахин боловсруулах 5 үйлдвэр байж байна. Яг өнөөдрийн байдлаар ажиллаж байгаа. Энэ бүх үйлдвэрүүд л үндсэндээ уул уурхай болоод бусад томоохон хүнд үйлдвэрээс гаргаж байгаа ажилласан тос, маслыг дахин боловсруулах ийм үйлдвэрүүд байж байна. Малын сэг зэмийг дахин боловсруулахтай холбоотой асуудлаар энэ онд Булган, Хөвсгөл аймгаас бол бидэнд санал ирсэн. Энэ дээр бол эхний ээлжид бол бид хэд малын гаралтай сэг

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

зэмийг бол дахин боловсруулах, устгахтай холбоотой үйлдвэрийн зураг төслийг хийлгэхээр бол 2026 оны төсөвтөө бол тусгасан байж байгаа.

Б.Бейсен: 2 номер хариулъя.

Б.Мөнхтогтох: Байгаль орчны хяналтын улсын хяналтын газрын дарга Мөнхтогтох. Тэгэхээр Бейсен гишүүний тавьж байгаа асуултууд дээр бол бас яг өөрийн харьяалалтай асуудал дээр тухайлбал арьс ширний үйлдвэрүүдийн аюулгүй байдалтай холбоотой, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа асуудалтай холбоотой асуудал дээр бол Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас бол хяналт шалгалтуудыг хийж байгаа.

Тэгэхээр хяналт шалгалт хийсэн асуудал дээр бол ингээд ярихаар бол нэлээн тоо баримтууд дурдмаар байна. Тухайлбал, Мишээл экспогийн тэнд байгаа арьс ширний үйлдвэрүүд дээр шалгалтуудыг хийсэн байгаа. Гэхдээ манай яамны зүгээс бол энэ хяналт шалгалттай холбоотой асуудлыг хуучин мэргэжлийн хяналтын байгууллага байсан түвшинд хийх гэдэг агуулгаар нь зөвхөн салбарынхаа хяналт шалгалтыг хийлгүй ийм хамтарсан хяналт шалгалт зохион байгуулах ажил дээр нэлээн анхаарч ажиллаж байгаа.

Тухайлбал, бид нар бол өнгөрсөн додоо хоног Торгон шир гэдэг компани дээр хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтыг тэгээд бид нар бол албан тоотууд явуулж байгаад Хүнс, хөдөө аж ахуйн яамтайгаа хамтраад.../минут дуусав./

Б.Бейсен: 2 номер гүйцээж яриулъя. 2 номерыг.

Б.Мөнхтогтох: Газар зохион байгуулалтын газартайгаа ингээд хамтраад хяналт шалгалтыг хийж байна. Тэгэхээр Наранбаатар гишүүний ярьж байгаа, Бейсен гишүүний ярьж байгаа асуудлууд үнэхээр яг зөв байгаа. Хуучин мэргэжлийн хяналтын байгууллага байхад бол хамтарсан хяналт шалгалтууд бол нэлээн их хүчтэй яваад асуудлыг бол цогцоор нь гаргаж ирдэг байсан. Одоо ингээд зөвхөн салбарынхаа асуудлыг шалгаад явахаар асуудлыг бол бүрэн утгаар нь гаргаж ирэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг. Бид нар ингээд холбогдох салбар яамнуудтай хамтарч ажиллахаас гадна илүү тийм бодлогын түвшинд асуудал шийдвэрлэх газруудтай хамтарч ажиллаж байна.

Тухайлбал, би Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтраад бол яг энэ Буянт голын асуудал дээр, Ховд голын бохирдол үүсгэж байгаатай холбоотой асууд тал дээр бол Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийнхөнтэй хамтарч ажилласан. Голын бохирдол маань бол яг юунаас болоод байна, асуудлыг бүрэн утгаар нь шийдвэрлэе. Энэ дээр хяналт шалгалтын байгууллага бол ямар агуулгаар нь ажиллаад хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэхтэй холбоотой асуудлыг бол.../минут дуусав./

Б.Бейсен: 1 номерын микрофон Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн.

Ж.Алтантуяа: Алтантуяа Сангийн яамны Төсвийн бодлого.

Б.Бейсен: Сангийн яамны юм уу?

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Ж.Алтантуяа: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөлтийн газрын шинжээч. Бейсен гишүүний асуултад хариулъя. 2026 оны төсвийн төсөлд Хог хаягдлын тухай хуульд заасан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хаягдлыг булшлах зэрэг хуульд заасан эдгээр арга хэмжээнд зориулж орон нутгийн аж ахуйн нэгж суурь зарлага дээр нийтдээ 96 тэрбум төгрөгийг төлөвлөсөн байж байгаа. Энэ төсөв маань болохоор 25 оны төсөвтэй харьцуулахад 9.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ийм төсвийг төлөвлөсөн байж байгаа.

Эрүүл мэндийн салбарын тухайд хог хаягдал, хортон мэрэгчдийн устгал, ариутгал зардлын зориулалтын.../минут дуусав./

Б.Бейсен: 1 номер гүйцээж яриулъя.

Ж.Алтантуяа: Нийтдээ 6.1 тэрбум төгрөгийн төсөв төсөвлөгдсөн байна.

Б.Бейсен: Тэр ер нь Улаанбаатар хотын бүх засварын газрууд уул уурхайгаас хэчнээн моторын хаягдал тос ер нь улсын хэмжээнд хэчнээн тонн хаягддаг юм байна ер нь? Энийг хэчнээн энэ газар булж байна, ер нь уул уурхайгаар явж үзсэн үү та бүгд?

4 номер.

Г.Энхмөнх: Шатах тос материалтай холбоотой асуудлаар бол 5 аж ахуйн нэгжийн 4 нь бол Улаанбаатар хотод ажиллаж байгаа. Тэгээд энэ гол бүтээгдэхүүнээ бол засварын газрууд олоод уул уурхайн компаниудаас нэгтгэн цуглуулж байгаа гэсэн үг. Түрүүнд нөгөө таны асуусан асуултад бас нэмээд хариулъя.

Нөгөө Эко стандарттай холбоотой асуудлаар. Эко стандартын хувьд бол өмнө нь төвлөрсөн шугам сүлжээнд хаягдал тос нийлүүлсэнтэй холбоотой асуудлаар бас экологийн цагдаад бол эрүү үүсгээд явж байсан ийм асуудал байгаа. Тэгээд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны дэргэдэх Хог хаягдлын мэргэжлийн зөвлөл дээр 2025 оны 3 сар, 6 сард бол 2 удаа хүсэлт ирүүлсэн байна. Тэгээд 3 сард бол мэргэжлийн зөвлөл юу гэж үзсэн гэхлээр тухайн өмнө нь гаргасан зөрчлийн гүйцэтгэл нь ямар байгаа юм бэ? Энэ талаар би.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Г.Энхмөнх: Зөрчлийн гүйцэтгэл, биелэлтээ ирүүл гэдэг ийм чиглэл өгөөд буцаасан байна лээ. Ингээд 2025 оны 6 сард дахин мэргэжлийн зөвлөл хэлэлцээд энэ үеэр тэр Сэргэлэн сум руу нүүхтэй холбоотой асуудал яригдсан юм байна лээ. Ингээд мэргэжлийн зөвлөл юу гэж үзсэн гэхлээр хэрвээ Сэргэлэн сум руу нүүхээр бол яг тэн дээрээ яг дахиж үнэлгээгээ хийлгээд хандах нь зүйтэй гэсэн ийм нэгдсэн шийдвэр бол өгсөн байна лээ. Тэр эмнэлгийн хог хаягдлын талаар Нийгмийн эрүүл мэндийн хүрүүлэн.

Б.Бейсен: 1 номер.

Б.Цэцэгсайхан: Бейсен гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар. Эрүүл

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

мэндийн байгууллагын хувьд бол халдвартай, хурц үзүүртэй хог хаягдал, эмгэг, эмийн хог хаягдал, химийн хог хаягдал гээд маш олон төрлийн аюултай хог хаягдал гардаг. Энийг бол Эрүүл мэндийн сайдын тушаалаар эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилан, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах гээд зааврын дагуу бол бүх эрүүл мэндийн байгууллагууд хог хаягдлаа ангилж явдаг.

Улаанбаатар хотын хувьд бол төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Элемент болон Элемент медиал гээд 2 компанид бол эрүүл мэндийн байгууллагууд хог хаягдлаа өгч устгуулдаг.

Аймаг, орон нутгийн хувьд бол эрүүл мэндийн байгууллагууд өөрсдөө дэргэдээ автоклав бол болон шатаах зуухтай. Эндээ эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг устгаж явдаг. Тэгэхээр манай салбарын хувьд бол ерөнхийдөө аюултай хог хаягдлын зохицуулалт, менежмент бол нэлээн бас харьцангуй гайгүй түвшинд явдаг.

Б.Бейсен: Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс нэмээд юм асууя. Энэ сургуулийн хүүхдүүд ясли, цэцэрлэг байж байна. Хог ялгах хаях тал дээр энэ боловсролын байгууллага дээр ямар санал тавиад хамтран ажиллаж байна? Яг бодитой хийж байгаа ажил байна уу энэ тал дээр?

Б.Цэцэгсайхан: Тэгэхээр иргэдэд нийгмийн эрүүл мэндийн, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр боловсролын байгууллагуудтай хамтарч ажилладаг. Энэ хүрээндээ бол мэдээж эрүүл мэндийн боловсрол яаж эрүүл байх вэ гэдэг зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр сургалтууд хийхээс гадна хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр бас тодорхой хэмжээний сургалтуудыг хийдэг. Гэсэн хэдий ч яг эцсийн хог хаягдлыг боловсруулах үйлдвэрийн асуудлууд тэрийгээ зөв менежмент хийх асуудлууд бас төдийлөн хангалттай биш л байдаг л даа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж дууслаа.

Мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Уянга гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн үг хэлье.

Ц.Идэрбат: Байгаль орчны яам энэ хогон дээр ер нь ямар бодлого баримталж байгаа гэдэг талаар бас сонслоо. Мэдээж бас бодлогын томоохон зүйлүүд бас төлөвлөөд ингээд явж байгаа юм байна. Миний яриад байгаа, хэлээд байгаа зүйл бол яг өнөөдөр амьдрал дээр тулгамдаад байгаа асуудлуудаа л эхлээд шийдчих ийм л зүйл яриад байгаа юм. Манай энэ аймаг, сумын хогны бүтэц чинь бол бас их онцлогтой шүү дээ. Тэгээд өвөлдөө бол үнс, хавартаа бол нүүрсний хог, намартаа шарилж, зундаа барилгын хог тэгээд хажуугаар нь чихэр жимсний цаас чинь ингээд л гялгар уут шиг явж байгаа байхгүй юу. Энийг их айхтар ангилж ялгаад л тэр нь зах зээлд ороод л эд нар тийм юм байхгүй. Та нар энэ хогийнхоо асуудлыг үнэхээр шийдье гэж байгаа бол энэ сумын дарга нартай онлайнаар ч хамаагүй хурал зохион байгуулаад одоо байгаа хууль, эрх зүйн орчин чинь юун дээр саад болоод байгаа юм бэ гэдгээ л шийдчихвэл ядаж нэг том алхам болно. Тэгээд тэр дараа дараагийн нийслэл дээр би сая тодрууллаа хог боловсруулах үйлдвэр Монголд анх удаа яг гэрээгээ байгуулах түвшиндээ л явж байгаа юм байна шүү дээ.

Тэгэхээр энэ 330 суманд тулгамдаад байгаа энэ асуудлыг шийдэхэд адаглаад тэр хогоо яаж шатаах юм бэ гэдэг стандарт юмыг нь хүртэл гаргаж өгөөд шатаалгачихмаар байгаа юм. Тэгээд хүн харахад нэвсийсэн хог. Очоод тэрийг чинь гялгар уутыг боловсруулна л гэж байна 25 кг-ийн шуудайд өдөржин тонголзоод дүүргэхэд 2 кг болдог юм шүү. 2 кг нь зах зээлийн үнэ нь 200 төгрөг шүү бараг. Хэн тэрний төлөө тэрийг түүх юм гээд ингээд та бүхний ярьж байгаа юм бол яг сум дээр байгаа тэр хогтой ноцолдож байгаа хүнд бол жоохон агаарын юм байна шүү. Тэгэхээр мэдээж алсын төлөвлөгөө байлгүй яах вэ. Өнөөдрийнхөө хөрсөн дээрээ буусан бас юм гаргаад энийгээ хэрэгжүүлээд өгчхөөч. Хууль, эрх зүйн ямар тээг, саад байгаа юм тэрийг нь нээгээд өгчхөөч гэж ингэж би бас хэлэх гээд байгаа юм. Нэгд тэр.

Хоёрт бол тэр яах вэ жижиг юм ярьж байгаа эд нар гэж зарим нь бодож магадгүй. Үнэхээр л яг тулгамдаж байгаа л юмыг би хэлэх гээд байгаа юм. Тэр 21 аймгийн төв дээр өнөөдөр бол тэгээд үхэр малаа цэгцэлж чадахгүй, нохой, гахайгаа цэгцэлж чадахгүй, хүн машин, үхэр мал, нохой, гахай бүгд зам дээр цувралдаад л явж байгаа шүү дээ. Тэгээд энийг шийдэхэд тухайн шатын Иргэдийн хурлын шийдвэр, Засаг даргын шийдвэр ингээд гаргадаг юм. Болохгүй гээд гаргадаг юм. Тэгээд болохгүйг нь мэдсээр байгаад зөрчсөн хүнийг яаж ч чаддаггүй байхгүй юу. Жоохон хатуухан гараар үзчихье гэхээр Хууль зүйн яам тэрийг нь бүртгэж авдаггүй юм. Ингээд нэг хэсэг нь тарьдаг, нэг хэсэг нь ердөө тэгээд үхэр малаа оруулаад ногоон байгууламж сүйтгээд, зам харгүй балиартуулаад, хажуу айлдаа, хажууд нь айл байж байхад гахай тэжээгээд ингээд байгаад байдаг байхгүй юу.

Тэгээд энэ мэтийн салбарын хууль, эрх зүйн зохицуулалт дутагдсанаас болоод анхан болон дунд шатанд ингээд байгаль орчинд нөлөөлөөд байгаа энэ асуудлуудыг та нар жижиг гэж харалгүйгээр шийдээд өгөөч ээ. Тэгээд би бол сайдаас та энийг бүр манлайлаад хийчхээч ээ. Мэдээж салбарын хувьд энэ том асуудлуудаа та хэд ингээд дэс дараатай явж байх л байх. Гэхдээ яг одоо анхан шатан дээр үүсээд байгаа энэ хог шорооныхоо асуудлыг хэдүүлээ шийдчихмээр байгаа юм, цэгцэлчихмээр байгаа юм. Тэр яах вэ тэр нь салхин дээрээ, доороо эд нар гэдгийг тэд нар чинь Монгол хүмүүс хараад өөрсдөө их шинжлүүлээд байх юм байхгүй шийдэж байна шүү дээ. Энэ бол их яамны бодлого биш гэж би бол зориуд хэлье.

Тэгэхээр энэ дээр би, тэр аюултай хог хаягдал өнөөдрийн түвшинд яригдаж байгаа энэ зүйл дээр тэр эмнэлгийнхэн эд нар бол зөв л хариулж байна л даа. Бас яадгаа алдчихсан юм бол бас байхгүй. Тодорхой хэмжээнд байж байгаа. Нийгэм өөрчлөгдөхийн хэрээр тэр баахан аккумуляторын шингэн гээд янз янзын юмнуудаа яах вэ, ийх вэ, уул уурхайн юмаа яах вэ гэдэг дээр өнөөдөр бас энэ Байнгын хорооноос шийдвэр гарч ажлын хэсэг гарах юм шиг байна. Тэгээд цаашаа тэгээд үргэлжлүүлээд хог хаягдал, энэ аюултай хог хаягдлаа бид нар яг өнөөдрийн энгийн хог хаягдал шиг хэдэн жилийн дараа яах вэ гэдгээ мэдэхгүй сууж байж болохгүй.

Б.Бейсен: Батжаргал гишүүн үг хэлье. Үг хэлж байна. Энэ хариулт байхгүй байх. Батжаргал гишүүн.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Ж.Батжаргал: Баярлалаа. Хог хаягдлын асуудал үнэхээрийн анхаарал татаж байгаа юу гэвэл анхаарал татаж байгаа асуудал. Бид шийдлээ гаргаж чадахгүй байгаа юм. Ний нуугүй үнэнийг хэлье. Тэгэхээр шийдлээ зөв гаргахын тулд энэ хууль тогтоомжийнхоо хэрэгжилтэд нэлээн бодитой үнэлгээ хийгээд тэгээд ямархуу байдалтай өөрчлөлт хийх юм бэ, тэр үйлдвэрлэгч, импортлогч нь хог хаягдлаа хариуцдаг, бохирдуулсан төлдөг энэ тэр гээд энэ зарчмаа яаж энэ шийдэл дотроо тусгах юм гэдэг асуудал өөрөө хамгийн гол зүйл байгаад байгаа юм. Монгол чинь энэ машиных нь тоо алийгаа алдчихсан.

Тэгээд 5-хан шатах тослох материал дахин боловсруулдаг үйлдвэртэй. Тэр нь Улаанбаатартаа гээд байгаа. Үгүй энэ чинь өнөө хамгийн их эзлэхүүн ихтэй солигддог юмнууд чинь наад хүнд даацын тээврийн хэрэгсэл уул уурхайн салбарт чинь л байгаа шүү дээ. Тэгээд тэнд нь юм байхгүй юм чинь энэ хог хаягдал яаж хаягдах юм? Тэндээс бохирдсон, сольсон тос ачиж ирээд энд боловсруулаагүй нь л ойлгомжтой шүү дээ. Үгүй тэгээд энэ амьдрал руугаа жоохон хэдүүлээ орж, үүнийгээ зөв шийдэхгүй бол болохгүй бид. Шийдэж чадаагүй. Ганц нэг жижиг юм яриад тэрүүгээр юм шийдсэн юм шиг ярьцгаагаад боломгүй байна. Хаана нөхцөл байдал бий болоод байгаа юм. Тэндээ тулгуурласан энэ тархвартай дахин боловсруулалтынхаа юмыг бид зөв шийдэх ёстой. Энэ рүүгээ орох нь би зөв болов уу гэж бодож байна.

Дараагийн хэлчихмээр байгаа санаа бол энэ хогуудыг чинь аваад үзэхээр зэрэг хэд хэдэн зүйл л их онцгой харагдаад байгаа шүү дээ. Энэ шилийг боловсруулахгүй юм уу хэдүүлээ? Импортлогч нарын энэ шилийг бид энэ үндэсний үйлдвэрүүд чинь авахгүй. Угаасаа ойлгомжтой. Өөрийнхийгөө авахгүй байгаа улс чинь. Тэгэхээр үүнийг яаж боловсруулах юм? Ерөөсөө хамгийн том хаягдал энд үүсээд байгаа.

Дараагийнх нь тэр дугуй чинь байгаад байгаа. Дараагийнх нь энэ шатах тослох материал чинь байгаад байгаа. Энэ хэдийгээ зөв шийдэх тухай асуудал бидэнд байгаад байгаа юм. Энэ бол эдийн засгийн эргэлтэд орчхож болохоор хаягдлууд байгаа байхгүй юу. Дахиад боловсруулахаар юм бодвол боловсрогдоод юм гардаг юм байж. Түүнд орохгүй үлдэж байгаа хаягдал нь хэдэн хувь байгаа юм бэ гэдэг асуудал байгаа байхгүй юу. Үүнийгээ яах юм гэдэг юмаа зөв шийдэх тухай.

Тэгэхээр би яагаад энийг яриад байна гэхээр зэрэг орон нутгууд чинь нэг үеэ бодвол санхүүгийн чадамж нэлээн өндөр болчихсон. Одоо гагцхүү арга зүй, стандарт гэдэг юм уу, техникийн зохицуулалт байхгүйгээр л асуудлаа шийдэж чадахгүй байгаад байгаа яг үнэнийг хэлэхэд. Тэгэхээр үүнийг нь зөв болгоод өгчихмөөр байна л даа. Энэ сум суурин газруудад ахуйн хог хаягдлаа ямархуу байдлаар шийдэх юм, эдийн засгийн эргэлтэд орчхож болохоор хог хаягдлаа ямархуу байдлаар шийдэх юм, энэ аюултай хог хаягдлынхаа жижиг юмнуудыг яаж шийдэх юм гэдэг юмнуудаа их тодорхой болгоод өгчихмөөр байна.

Улсын хэмжээнд ганцхан аюултай хог хаягдлын дахин боловсруулалт ийм Сэргэлэнгийн нутаг дээр 20 га газрын тухай олон жил ярьж байгаа юм. Би аймгийн дарга байхдаа зөвшөөрөөгүй юм. Тэр хог үйлдвэрлэж байгаа засаг захиргааны нэгж нь өөрөө газраа шийдэж асуудлаа шийд ээ. Бид улсуудын бий болгосон аюултай хог хаягдлыг булшилдаг газар биш гэж хэлээд шийдэхгүй нэг юм хэсэг явсан юм наадхыг чинь. Ер нь тийм шүү дээ яг нарийндаа. Хүний бий болгосон

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

аюултай, хортой хаягдлыг булшилдаг газар байж таарахгүй шүү дээ. Дараа нь их аймаар юм болно. Ер нь цаашид бодох ёстой энэ Монголын төр энэ чимээгүй хот буюу энэ оршуулгын газраа яах юм гэдэг асуудал. Дан дамаа хүн ам их суурьшигчсан энэ Улаанбаатарын орчмын энэ асуудал жилээс жилд алийгаа алдана. Одоо сайхан тийм.../минут дуусав./

Б.Бейсен: Уянга гишүүн үг хэлье.

Б.Уянга: Байгаль орчны сайд байгаа дээр, бас албаны хүмүүс байгаа дээр зүйлийг заавал тэмдэглэн хэлэхийг хүссэн юм. Хог хаягдлын тухай хууль бол хурдан сайжруулах энэ асуудал дээр анхаарал хандуулж ажиллахыг хүсье. Хувь гишүүний хувиар энэ дахь хогийг дахин боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих энэ асуудал дээр бол их анхаарч ажиллах ийм шаардлагатай байгааг ойлгож байгаа. Тэгээд зүгээр “Тогтвортой ногоон хөгжил” ТББ-аас ирсэн албан бичиг дээр болохоороо ийм агуулга байсан юм. Тэр нь болохоороо эмнэлгийн хог хаягдал нь болохоор Эрүүл мэндийн яаманд харьяалагддаг. Барилгын хог хаягдал нь Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам, энгийн хог хаягдал нь Хөдөө аж ахуйн яам тэгээд хаягдал металл боловсруулах үйлдвэрүүд нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам байна тэгээд дундын энэ хаягдлыг авах, боловсруулах, дундын асуудлуудаа шийдвэрлэхэд олон яам ингээд хамаардаг учраас асуудалтай байна. Энийг анхаарч өгөөч гэсэн байсан. Тэгэхээр энэ дээр салбар яам маань хуулийн зохицуулалт дээрээ сайн ажиллаж өгөх хэрэгтэй. Тэгээд өшөө бас энэ дахин боловсруулах үйлдвэрүүдийг яг яаж дэмжих юм гэдэг дээр бас гаргалгаа шийдэл хайсан янз бүрийн хэлэлцүүлгүүд одоохондоо бас янз бүрийн уулзалтуудыг бас зохион байгуулж хамтарч ажиллахад бэлэн байгаагаа хэлье.

Б.Бейсен: Хог хаягдлын асуудал нь үнэхээр тулгамдсан асуудал болж байна. Тийм учраас энэ бид энэ ажлын хэсэг бас байгуулах гэж байгаа. Энэ ажлын хэсгийнхэн бас энэ дахин боловсруулах үйлдвэрүүдээр бас очоод танилцаарай. Энэ Байгаль орчны яамныхан холбогдох улсуудыг дагуулж очоод бас танилцах шаардлагатай байгаа. Сая Эко стандарт тэр хаягдал цасны энэ ариун цэврийн цаас, салфетка энэ тэр үйлдвэрлэж байгаа газрууд байж байна. Тэнд бас хэрэглээд мөөгөнцөр үүссэн гээд улсууд яриад бас хүсэлт ирчихсэн байгаа. Тэгэхээр энэ ажлын хэсэг бас тэнд очоод танилцах шаардлагатай байгаа.

Нөгөө талаар Байгаль орчны яам, энэ Хүнс, хөдөө аж ахуйн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэнд хүрээлэн хамтарч байгаад энэ хуульд өөрчлөлт оруулаад, энэ ажлын хэсэгтэй хамтарч байгаад асуудлыг шийдээд дахин боловсруулах үйлдвэр байгуулах асуудлыг тавихгүй бол Улаанбаатар хот том том хотууд байна. Дархан, Налайх, аймгийн төвүүд байж байна. 1 ч дахин боловсруулах үйлдвэр байдаггүй. Нөгөө талаар урамшууллын зүгээр цуглуулаад газар булж байгаа улсууд урамшуулал авдаг дахин боловсрох үйлдвэр байхгүй, боловсрох үйлдвэр нэртэй авч байгаа улс газар ч байж байна.

Тийм учраас энийг бүгдийг нь судалгааг нь гаргаад энэ төр засагтаа яагаад төсөв, дараа жилийн төсөвт тусгах асуудал дээр ер нь Батбаатар сайд бас манай гишүүд бас анхаарлаа хандуулаад энэ дээр ажиллахгүй бол ялангуяа Улаанбаатар хотын хэмжээнд аймгийн төв том том хотууд дээр энийг анхаарахгүй бол энэ гадаад орнуудаар очоод судалсан бид нар төрөл бүрээр нь ялгадаг. Эд

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нар сургуулийн хүүхдүүдээс ингэж сургадаг юм байна. Хогоо ялгаж хадгалах асуудал дээр. Дараа нь үйлдвэр дахин боловсруулах үйлдвэр тушаадаг.

Гэтэл манай боловсролын байгууллага, эрүүл мэндийн байгууллага энэ дээр бас анхаарлаа хандуулдаггүй. Эмнэлгийн хог хаягдал бол маш аюултай юм байгаа юм. Сая газрын тосны асуудал байж байна. Газар булж байна гэж юу гэсэн үг вэ? Газрын хэвлийг бохирдуулж байна. Дахин боловсруулах үйлдвэрт тэр нөгөө эко стандартыг чинь би эхлээд загнаад танайх чинь түлш ямар юм байна гээд шалгаад үзсэн. Гэтэл үнэхээр түлш гаргадаг юм байна. Ингээд түлш хомсдох үед нь бас тийм юм байвал бас сайн шүү дээ. Тийм учраас тэн дээр бас анхаарлаа хандуулж ажиллаарай гэж хэлье.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.13 дахь заалт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Мөнхсоёл Монгол Улсын Их Хурлын гишүүн, гишүүдэд Н.Алтаншагай Монгол Улсын Их Хурлын гишүүн, С.Ганбаатар Монгол Улсын Их Хурлын гишүүн, Ж.Золжаргал Монгол Улсын Их Хурлын гишүүн, А.Ундраа Монгол Улсын Их Хурлын гишүүн, Б.Уянга Монгол Улсын Их Хурлын гишүүн, Салдангийн Одонтуяа Монгол Улсын Их Хурлын гишүүн, Т.Мөнхсайхан Их Хурлын гишүүн гээд ийм бүрэлдэхүүнтэй байгуулж байгаа.

Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллага албан тушаалтныг тухай бүр татан оролцуулах ажлын хэсэгт зөвшөөрсүгэй. Мөнхсоёлд.

Гуравд энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дарга Бейсенд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байгаа.

Тогтоолын төсөлд саналтай гишүүн байна уу?

Та тэртээ тэргүй оролцоод явна. Тийм. Намрын чуулган хүртэл ирэх жилийн төсвөөс наана нь яах ёстой л доо. Тэрийг нэмээд санал ажлын хэсэг маань юундаа тусгачхаарай.

Тогтоолын төслийг батлах уу? Санал хураалтад бэлдээрэй. Санал хураалтад бэлдээрэй. Замира гишүүн нэмж санал оруулж байх шиг байна. Замира гишүүнийг нэмчхээрэй. Санал хураалт.

Тогтоолын төсөл 58.8 хувиар батлагдлаа.

Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул хурлаа хаасныг мэдэгдье.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Гишүүдэд баярлалаа. 14 цагаас усны асуудлаар хэлэлцүүлэгтэй шүү манай Байнгын хорооны гишүүд ээ. Говийн усны асуудлаар. 14 цагаас. Хурал хаасныг мэдэгдье.

13.42 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР